



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬГА  
ХЭНТИЙ АЙМГИЙН  
АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг бар  
Утас 70-56-21-47, Факс: 70-56-21-12  
E-mail: khentii@audit.gov.mn

2016.11.19 № 282  
таний -ы № -т

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын 2016 оны ээлжит сонгуулийн  
зардлын дүн, хандивын талаарх мэдээлэл

Хэнтий аймгийн Аудитын газар нам, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланг Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1-т зааснаар аймгийн Сонгуулийн хорооноос хүлээн авч хянан, сонгуулийн зардлын дүн, нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3-т заасны дагуу мэдээлж байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуульд 3 нам, 86 нэр дэвшигч оролцсон бөгөөд аймгийн Сонгуулийн хороо 2016 оны 11 дүгээр сарын 11-ны өдөр сонгуульд оролцсон 2 нам, 75 нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг аймгийн Аудитын газарт ирүүлсэн байна.

Аймгийн сонгуулийн хороонд аймгийн ИТХ-ын сонгуульд оролцсон МАН, МАХН зардлын тайлангаа ирүүлсэн бол Ардчилсан нам зардлын тайлангаа ирүүлээгүй байна.

1. Аймгийн Сонгуулийн хороонд зардлын тайлангаа ирүүлсэн МАН 15.1 сая төгрөгийн, МАХН 1.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн зарцуулсан байна.  
Сонгуульд оролцсон МАН, МАХН намд 2.0 сая төгрөг ба түүнээс дээш хандив өгсөн хуулийн этгээд байхгүй бөгөөд МАН-д 1.0 сая төгрөгийн хандивыг 3 иргэнээс нийт 3 сая төгрөгийн мөнгөн хандив төвлөрсөн байна.
2. Аймгийн Сонгуулийн хороонд зардлын тайлангаа ирүүлсэн 75 нэр дэвшигчийн зардлын тайлангийн нэгтгэсэн дүнгээр нийт 208.3 сая төгрөг төвлөрсний 6.4 сая төгрөг нь хуулийн этгээдээс, 81.5 сая төгрөг нь иргэдээс өгсөн хандивын орлого, 28.9 сая төгрөг нь АН, 1.2 сая төгрөг нь МАН –аас нэр дэвшигчид өгсөн дэмжлэг бол 90.4 сая төгрөг нь нэр дэвшигчдийн өөрийн хөрөнгө байна.  
Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцсон 2 нэр дэвшигчид тус бүр 2.0 сая төгрөгийн хандивыг нэг хуулийн этгээд өгсөн бол нэр дэвшигчдэд 1.0 сая төгрөгөөс дээш хандив өгсөн 25 иргэнээс нийт 40.5 сая төгрөгийн хандив төвлөрсөн байна.  
Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчид нийт 195.4 сая төгрөгийг сонгуульд зориулан зарцуулжээ.
3. Сонгуульд оролцсон нэр дэвшигчдээс 11 хүн зардлын тайлангаа аймгийн Сонгуулийн хороонд ирүүлээгүй байгаа нь Сонгуулийн тухай хуулийн 59.1-д " Энэ хуульд өөрөөр заагаагүй бол орон нутгийн хурлын сонгуульд нэр дэвшигч нь санал хураалт яваадсан өдрөөс хойш 30 хоногт багтаан сонгуулийн зардлын тайлан гаргаж тухайн шатны сонгуулийн байгууллагад хүргүүлэх үүрэгтэй" гэсэн заалтыг зөрчсөн байна.

0611-00

Сонгуулийн хорооноос ирүүлсэн зардлын тайланг хянах явцад дараах зөрчил дутагдал илэрсэн. Үүнд: Сонгуулийн тухай хуулийн 47.5 дахь заалтыг зөрчиж сонгуулийн зардлын данс нээлгээгүй нэр дэвшигч 1, 59.2 дахь заалтыг зөрчиж дансны хуулга ирүүлээгүй нэр дэвшигч 27, 59.3 дахь заалтыг зөрчиж банкнаас дансны тайлан ирүүлээгүй 42 хүн, 50.4 дэхь заалтыг зөрчиж хандив өгсөн иргэний регистрийн дугаар тавиагүй 16 хүн, 59.2.1 дэхь заалтыг зөрчиж нийт 25.5 сая төгрөгийн өөрийн хөрөнгийг дансанд төвлөрүүлээгүй 10 нэр дэвшигч байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



ЦЭНХТҮВШИН